



**ЗОРЧИХ ВИЗ АНГИЛАЛ 676
МОНГОЛ УЛСЫН ВИЗ МЭДҮҮЛЭГЧИД**

Бүрдүүлэх Материалын Жагсаалт

Анхаарвал зохих зүйлс:

- Доор дурдагдах бичиг баримтуудын хуулбарыг ирүүлэх
- Гадаад паспортаас бусад бичиг баримтын эх хувийг ирүүлэхгүй байх
- Албан ёсны бичиг баримтуудыг нотариатаар баталгаажуулсан байх
- Монгол хэл дээрх бүх бичиг баримтыг баталгаат орчуулгаар Англи хэлрүү хөрвүүлсэн байх
- Энэхүү жагсаалыг бүрэн гүйцэд бөглөн мэдүүлэгийн материалын дээд талд хавсаргах

Мэдүүлэгийн Маягт болон Хураамж	√ Сонгох
Мэдүүлэгийн Маягт 48 http://www.immi.gov.au/allforms/pdf/48r.pdf Англи хэлээр бөглөсөн байна.	<input type="checkbox"/>
Маягт 54 - Гэр Бүлийн Гишүүдийн Жагсаалт http://www.immi.gov.au/allforms/pdf/54.pdf Англи хэлээр бөглөсөн байна.	<input type="checkbox"/>
Маягт 956 - Цагаачлалын агентлаг болон зөвшөөрөлтэй эрх бүхий этгээд http://www.immi.gov.au/allforms/pdf/956.pdf Зөвхөн цагаачлалын агентлагаар дамжуулж мэдүүлэг өгөх эсвэл таны мэдүүлэгийн талаар мэдээлэл авах эрх бүхий этгээдийг сонгосон тохиолдолд бөглөнө.	<input type="checkbox"/>
Виз мэдүүлэгийн хураамж http://www.china.embassy.gov.au/bjng/DIACtemp.html -д орж танилцана уу.	<input type="checkbox"/>
ХУВИЙН БИЧИГ БАРИМТ	√ Сонгох
Одоогийн хэрэглэж буй хүчинтэй гадаад паспорт болон ойрын хугацаанд хэрэглэгдсэн хуучин паспорт (Эх хувь)	<input type="checkbox"/>
Гадаад паспортын (зурагтай) нүүр хуудасны хуулбар	<input type="checkbox"/>
Паспортын хэмжээтэй зураг нэг хувь, зургыг мэдүүлэгийн маягттай хавсаргасан байна.	<input type="checkbox"/>
Мэдүүлэг өгөх хүн бүрийн иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар	<input type="checkbox"/>
САНХҮҮГИЙН БИЧИГ БАРИМТ	√ Сонгох
Аялалаа санхүүжүүлэх чадвартайг нотлох баримт: <ul style="list-style-type: none">• Хуримтлуулсан мөнгөн хөрөнгийг харуулах банкны хадгаламжын дэвтэр• Банкны тодорхойлолт эсвэл хэсэг хугацаанд олгосон цалингын хуудас• Кредит карт• Бусад үндсэн хөрөнгө, ашиг болон орлогын бичиг баримт	<input type="checkbox"/>
Хэрэв таны аялалын зардлыг Австрали улсад амьдарч буй найз эсвэл хамаатан садан тань хариуцах бол санхүүжүүлэх тухай мэдэгдэл захиа мөн санхүүжүүлэх чадвартайг харуулах нотолгоо баримт ирүүлнэ.	<input type="checkbox"/>

АЖИЛ БОЛОН СУРГУУЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	√ Сонгох
Хэрэв та ажил эрхэлдэг бол ажил олгогчын гарын үсэгтэй тодорхойлолт, үүнд доорх мэдээлэл багтсан байна: <ul style="list-style-type: none"> • таны албан тушаал болон цалин • таны ажил эрхэлсэн нийт хугацаа • чөлөө олгосон зөвшөөрөл • тодорхойлолтод гарын үсэг зурсан ажил олгогчтой холбоо барих мэдээлэл • нийгмийн даатгалын дэвтэр 	<input type="checkbox"/>
Хэрэв та ямар нэгэн бизнес эрхэлдэг бол бизнесийн гэрчилгээний хуулбар	<input type="checkbox"/>
Хэрэв та тэтгэвэрт гарсан бол Тэтгэвэрийн Дэвтрийн хуулбар	<input type="checkbox"/>
Хэрэв та окутан бол сургуулийн тодорхойлолт	<input type="checkbox"/>
БУСАД БИЧИГ БАРИМТ	√ Сонгох
Хэрэв таньтай холбогдох шуудангын хаяг Монгол улсад бол доорх мэдээллийг багтаасан 2 ширхэг хаягын хуудас ирүүлнэ. <ul style="list-style-type: none"> • Мэдүүлэгчийн нэр, Монгол хэл дээр • Холбоо барих шуудангын хаяг, Монгол хэл дээр • Холбоо барих утасны дугаар 	<input type="checkbox"/>
Хэрэв та Австрали улсад амьдарч буй хамаатан садан, найзындаа зочилох бол доорх бичиг баримтыг ирүүлнэ, үүнд: <ul style="list-style-type: none"> • Уриж буй этгээдийн холбоо барих хаяг • Уриж буй этгээдийн гадаад паспортын нүүр хуудас болон Австралын визтэй хуудасны хуулбар 	<input type="checkbox"/>
Зарим мэдүүлэгчид нэмэлт бичиг баримт бүрдүүлэх шаардлагатай болдог. Тиймээс Зарим Мэдүүлэгчид Шаардагдах Нэмэлт Бичиг Баримттай танилцана уу.	<input type="checkbox"/>

ЗАРИМ МЭДҮҮЛЭЧИДЭД ШААРДАГДАХ НЭМЭЛТ БИЧИГ БАРИМТ

3 САРААС ДЭЭШ ХУГАЦААГААР ЗОРЧИХ МЭДҮҮЛЭГЧИД	√ Сонгох
Хэрэв та Австрали улсад 3 сараас дээш хугацаагаар аялах бол эрүүл мэндийн үзлэг болон цээжин биеийн X-Ray шинжилгээ хийлгэх шаардлага гарч болзошгүй. Монгол улс дахь албан ёсны зөвшөөрөлтэй эмнэлэгийн талаарх мэдээллийг http://www.china.embassy.gov.au/bjng/DIMA0402.html -д орж авна уу.	<input type="checkbox"/>

75 БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ МЭДҮҮЛЭГЧИД	√ Сонгох
Та 75 болон түүнээс дээш настай бөгөөд эрүүл мэндийн үзлэгт орох заавар хараахан аваагүй бол Өндөр Настны Эрүүл Мэндийн Үзлэг хийлгэх шаардлагатай болно. Эрүүл мэндийн үзлэгийг Австралийн Засгын Газраас албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн эмнэлэгт хийлгэнэ. Монгол улс дахь албан ёсны зөвшөөрөлтэй эмнэлэгийн талаарх мэдээллийг http://www.china.embassy.gov.au/bjng/DIMA0402.html -д орж авна уу.	<input type="checkbox"/>
Эрүүл мэндийн/аялалын даатгал хийлгэсэн гэх нотолгоо ирүүлнэ. Энэ нь аялалын даатгал эсвэл эрүүл мэндийн даатгал хэлбэрээр байж болох хэдий ч Австрали улсад аялах хугацаанд гарч болзошгүй ямар нэгэн эмчилгээний зардлыг бүрэн даах ёстой.	<input type="checkbox"/>
АНХААР: Манай хэлтэсээс эрүүл мэндийн/аялалын даатгалыг шаардахаас өмнө даатгал худалдан авахгүй байхыг анхаар.	

18 НАС ХҮРЭЭГҮЙ МЭДҮҮЛЭГЧИД	√ Сонгох
<p>Эцэг/эх үр хүүхэд мөн гэх нотолгоо баримт</p> <ul style="list-style-type: none"> • хүүхэдийн төрсний гэрчилгээ, эцэг эхийн нэр тус тус бичигдсэн байх • эцэг эхийн гэрлэлтийн гэрчилгээ (хэрэв ирүүлэх боломжтой бол) <p>Хүүхэдийн сургуулийн тодорхойлолт (хэрэв ирүүлэх боломжтой бол)</p> <p>Эцэг эх эсвэл хууль ёсны асран халамжлагчгүйгээр суралцах бол доорх бичиг баримт шаардлагатай, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хамт зорчихгүй эцэг эхийн иргэний үнэмлэх • Хамт зорчихгүй эцэг эхийн гарын үсэгээр баталгаажсан мэдэгдэл, мэдэгдэл доорх мэдээлэл багтсан байна, үүнд: <ul style="list-style-type: none"> • хүүхэдээ суралцахад зөвшөөрч буй талаар • хэр хугацаагаар суралцах болон суралцахаад явах он сар өдөр • нэг удаа зорчих эсвэл олон удаа зорчих зөвшөөрөл олгосон тухай • холбоо барих утас хаяг гэх мэт <p>Маягт 1229 -18 хүрээгүй мэдүүлэгчид Австрали улсад аялах зөвшөөрөл олгох тухай http://www.immi.gov.au/allforms/pdf/1229.pdf -д орж танилцаарай.</p> <p>Хэрэв тухайн хүүхэдийг Австрали улсад суралцах хугацаанд хагралзагч этгээд нь түүний эцэг/эх, хамаатан садан болон хууль ёсны асран халамжлагч биш бол тухайн этгээд нь хүүхэдийг Австрали улсад суралцах хугацаанд арсан халамжлана гэдгээ мэдэгдэж захиа ирүүлнэ.</p> <p>Маягт 1229 - 18 нас хүрээгүй мэдүүлэгчийг Австрали улсад суралцах хугацаанд нь асран халамжлах тухай мэдэгдэл http://www.immi.gov.au/allforms/pdf/1257.pdf -д орж танилцаарай</p> <p><i>Хүүхэдийн асран халамжлалтай холбоотой асуудал гарвал, бид илүү бичиг баримт шаардах болно.</i></p>	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>

ГРҮПЭЭР АЯЛАХ МЭДҮҮЛЭГЧИД	√ Сонгох
<p>Грүп аялалын зохион байгуулагч нь бүх мэдүүлэгийг хамт ирүүлэхээс гадна, доорх бичиг баримтыг бүрдүүлсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> • зохион байгуулагчын гарын үсэгтэй аялалын тухай захиа • аялалын бүрэн маршрут • оролцох мэдүүлэгчдийн нэрс 	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>